



ДАРХАН-УУЛ АЙМГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН
ТОГТООЛ
ОРОН ТООНЫ БУС ЗӨВЛӨЛ БАЙГУУЛАХ ТУХАЙ

2005 оны 10 дугаар сарын 13-ны өдөр Дархан

Дугаар 83

Монгол улсын Хүүхдийн эрхийг хамгаалах тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 2 дахь заалт, Хүүхдийн болон түүний эсрэг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх аймгийн дэд хөтөлбөрийн 5 дахь хэсгийн 6 дугаар заалтыг үндэслэн аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс **ТОГТООХ НЬ:**

1. Хүүхдийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, тэдний эрх ашгийг хамгаалах, хүмүүжил, ёс зүйн асуудлыг хариуцсан “Хүүхдийг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх” орон тооны бус зөвлөлийг Ерөнхий боловсролын сургуулиудын дэргэд байгуулан ажиллуулахыг захирал, эрхлэгч нарт үүрэг болгосугай.

2. “Хүүхдийг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх” орон тооны бус зөвлөлийн ажиллах чиглэл, зөвлөмжийг хавсралтаар баталсугай.

3. Ерөнхий боловсролын сургуулиудын дэргэдэх “Хүүхдийг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх” орон тооны бус зөвлөлийн үйл ажиллагаанд хяналт тавьж ажиллахыг аймгийн ИТХ-ын дэргэдэх НХХХЭЗөвлөл /Р.Тунгалаг-Эрдэнэ/, Нийгмийн бодлого зохицуулатын хэлтэс /Р.Батжаргал/, Цагдаагийн газрын Хүүхдийн албаны байцаагч нарт үүрэг болгосугай.



ДАРГА

Л.ГҮНЧИН

НАРИЙН БИЧГИЙН ДАРГА
Р.ТУНГАЛАГ-ЭРДЭНЭ